



## ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

### САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Өмнөговь аймгийн Мандал-Овоо сумын соёлын төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: **ӨМА-2026/031/НА-СТА-ТШЗ**

|  |   |
|--|---|
| <p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a><br/>Өмнөговь аймаг<br/>2026 он</p> | <p>Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,<br/>тэргүүлэх аудитор: Ц.Өсөхбаяр<br/>Утас: 70533539 Цахим хаяг: <a href="mailto:usukhbayarts@audit.gov.mn">usukhbayarts@audit.gov.mn</a><br/>Аудитын менежер: Т.Хонгорзул<br/>Утас: 70533552 Цахим хаяг: <a href="mailto:khongorzult@audit.gov.mn">khongorzult@audit.gov.mn</a><br/>Ахлах аудитор: Г.Шижирболд<br/>Утас: 70533552 Цахим хаяг: <a href="mailto:umnugovi@audit.gov.mn">umnugovi@audit.gov.mn</a><br/>Азуре хүлүг аудит ХХК-ийн гүйцэтгэх захирал: Г.Мөнхбаяр<br/>Утас: 70110090 Цахим хаяг: <a href="mailto:audit@azure.mn">audit@azure.mn</a></p> |
|--|---|

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Нутгийн удирдлагын ордон 304 тоот, 3 дугаар баг,  
Даланзадгад сум, Өмнөговь аймаг, 46083  
Утас: (976) 7053 3539, Цахим хуудас: www.audit.mn  
Цахим шуудан: umnugovi@audit.gov.mn

2026.02.24 № 95  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН МАНДАЛ-  
ОВОО СУМЫН СОЁЛЫН ТӨВИЙН  
ДАРГА А.АРИУНЖАРГАЛ ТАНАА

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Өмнөговь аймгийн Мандал-Овоо сумын соёлын төвийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

**Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Нийгмийн даатгалын өглөгтэй, төсвийн зарлагын ангилал зөрчиж худалдан авалт хийсэн, татвар, нийгмийн даатгалын төлбөр тооцоог шилжүүлэхдээ холбогдох өр төлбөрийн дансаар дамжуулж бүртгээгүй зэрэг 33,530.4 мянган төгрөгийн зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 6.4.8, 16 дугаар зүйлийн 16.5.5, 16.5.6, 26 дугаар зүйлийн 26.1, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 6 дугаар зүйлийн 6.1, 13 дугаар зүйлийн 13.4, 18 дугаар зүйлийн 18.1, 19 дүгээр зүйлийн 19.1 дэх заалтуудтай нийцээгүй бөгөөд санхүүгийн тайлагналын иж бүрэн байх, үнэлгээ ба хуваарилалт, толилуулга, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

**Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, Говийн оюу хөгжлийн сангаас 51,572.0 мянган төгрөгийн ширээ сандал, ном, тоног төхөөрөмж нийлүүлэгдэж, 30,618.9 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг данснаас хассан байна.

4626050110

Б-2 Бичиг үзрэг/2026оно/СТА-1 дүгнэлт/Төсвийн Дотоо

### **Аудитын гол асуудал**

Өмнөговь аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд хэрэгжиж буй “Нутгийн дэм” хөтөлбөр, орон нутгийн нэмэгдэлд хамрагдаж, байгууллагын албан хаагчдад нийт 37,633.5 мянган төгрөгийн цалин, урамшуулал олгосон байна.

### **Бусад асуудал хэсэг**

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгасан 6 зорилтын хүрээнд 15 арга хэмжээг хэрэгжүүлэн 85 хувийн гүйцэтгэлтэй дүгнүүлсэн байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ӨСӨХБАЯР

## 2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

| Данс       | Балансын зүйл   | Эхний үлдэгдэл        | Эцсийн үлдэгдэл       |
|------------|---|-----------------------|-----------------------|
| <b>35</b>  | <b>БАРАА МАТЕРИАЛ</b>   | <b>48,465,993.60</b>  | <b>56,624,493.60</b>  |
| <b>354</b> | <b>Хангамжийн материал</b>  | <b>48,465,993.60</b>  | <b>56,624,493.60</b>  |
| 3542       | Аж ахуйн материал   | 20,215,993.60         | 28,374,493.60         |
| 3545       | Барилгын засварын материал  | 28,250,000.00         | 28,250,000.00         |
| <b>I</b>   | <b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>  | <b>48,465,993.60</b>  | <b>56,624,493.60</b>  |
| <b>39</b>  | <b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>   | <b>908,200,818.92</b> | <b>885,278,213.08</b> |
| <b>392</b> | <b>Биет хөрөнгө</b>   | <b>890,436,818.92</b> | <b>865,826,713.05</b> |
| 39201      | Барилга, байгууламж, орон сууц  | 649,133,182.04        | 649,133,182.04        |
| 39202      | Хуримтлагдсан элэгдэл   | (92,971,981.80)       | (106,064,237.79)      |
| 39205      | Машин тоног төхөөрөмж (компьютер)                                     | 355,669,777.40        | 368,111,938.40        |
| 39206      | Хуримтлагдсан элэгдэл   | (131,767,114.70)      | (154,406,125.79)      |
| 39207      | Тавилга, аж ахуйн эд хогшил   | 111,300,100.00        | 120,711,000.00        |
| 39208      | Хуримтлагдсан элэгдэл   | (32,390,766.02)       | (42,912,666.01)       |
| 39213      | Түүх соёл, музейн дурсгалт зүйлс                                      | 21,077,700.00         | 21,077,700.00         |
| 39214      | Бусад үндсэн хөрөнгө  | 2,250,000.00          | 2,250,000.00          |
| 39215      | Хуримтлагдсан элэгдэл   | (1,890,000.00)        | (2,099,999.80)        |
| 39217      | Ном   | 10,025,922.00         | 10,025,922.00         |
| <b>393</b> | <b>Биет бус хөрөнгө</b>   | <b>17,764,000.00</b>  | <b>19,451,500.03</b>  |
| 39303      | Бусад биет бус хөрөнгө  | 17,764,000.00         | 19,534,000.00         |
| 39304      | Хуримтлагдсан элэгдэл   | -                     | (82,499.97)           |
| <b>II</b>  | <b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>                                    | <b>908,200,818.92</b> | <b>885,278,213.08</b> |
| <b>III</b> | <b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>                                    | <b>956,666,812.52</b> | <b>941,902,706.68</b> |
| <b>41</b>  | <b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>                                      | -                     | <b>1,094,146.01</b>   |
| <b>413</b> | <b>Өглөг</b>  | -                     | <b>1,094,146.01</b>   |
| 4131       | Ажилчидтай холбогдсон өглөг   | -                     | 1,094,146.01          |
| <b>IV</b>  | <b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>   | -                     | <b>1,094,146.01</b>   |
| <b>51</b>  | <b>Засгийн газрын хувь оролцоо</b>                                    | <b>956,666,812.52</b> | <b>940,808,560.67</b> |
| 511        | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 489,627,050.91        | 489,627,050.91        |
| 51101      | Өмч: - төрийн   | 475,871,050.91        | 475,871,050.91        |
| <b>512</b> | <b>Хуримтлагдсан үр дүн</b>   | <b>331,871,441.72</b> | <b>316,013,189.87</b> |
| 5121       | Өмнөх үеийн үр дүн  | 331,871,441.72        | 331,871,441.72        |
| 5122       | Тайлант үеийн үр дүн  | -                     | (15,858,251.85)       |
| 513        | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү                                      | 135,168,319.89        | 135,168,319.89        |
| <b>V</b>   | <b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>                                       | <b>956,666,812.52</b> | <b>940,808,560.67</b> |
| <b>VI</b>  | <b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>                    | <b>956,666,812.52</b> | <b>941,902,706.68</b> |

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

| Данс        | Үзүүлэлт  | Өмнөх он              | Тайлант он            |
|-------------|---|-----------------------|-----------------------|
| <b>13</b>   | <b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>                                | <b>388,945,576.15</b> | <b>402,827,600.00</b> |
| <b>1310</b> | <b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>                                      | <b>222,265,976.15</b> | <b>213,133,600.00</b> |
| 131001      | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт                                   | 222,265,976.15        | 213,133,600.00        |
| <b>1320</b> | <b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>                               | <b>166,679,600.00</b> | <b>189,694,000.00</b> |
| 132001      | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 166,679,600.00        | 189,694,000.00        |
| <b>12</b>   | <b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>  | <b>174,686,525.46</b> | <b>115,568,916.00</b> |
| <b>120</b>  | <b>Нийтлэг татварын бус орлого</b>                                  | <b>174,686,525.46</b> | <b>115,568,916.00</b> |
| 120004      | Төсөв байгууллагын өөрийн орлого                                    | 46,714,525.46         | 107,520,916.00        |
| 1200042     | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих                           | 41,544,525.46         | 55,948,916.00         |
| 1200045     | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого                                   | 5,170,000.00          | 51,572,000.00         |
| 120017      | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө                  | 83,399,000.00         | -                     |

|             |   |                       |                        |
|-------------|---|-----------------------|------------------------|
| 120018      | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал                                    | 44,573,000.00         | 8,048,000.00           |
| <b>I</b>    | <b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>  | <b>563,632,101.61</b> | <b>518,396,516.00</b>  |
| <b>21</b>   | <b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>  | <b>556,497,400.23</b> | <b>534,174,767.67</b>  |
| <b>210</b>  | <b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>  | <b>453,122,772.52</b> | <b>476,303,121.69</b>  |
| <b>2101</b> | <b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>  | <b>171,011,576.26</b> | <b>212,123,145.16</b>  |
| 210101      | Үндсэн цалин  | 127,384,180.21        | 131,603,106.86         |
| 210102      | Нэмэгдэл  | 36,037,246.05         | 71,796,748.68          |
| 210104      | Урамшуулал  | 7,590,150.00          | 8,723,289.62           |
| <b>2102</b> | <b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>                                 | <b>21,251,675.08</b>  | <b>28,332,922.97</b>   |
| 210201      | Тэтгэврийн даатгал  | 14,581,933.49         | 19,452,228.19          |
| 210202      | Тэтгэмжийн даатгал  | 1,615,731.41          | 2,220,112.80           |
| 210203      | ҮОМШӨ-ний даатгал   | 812,536.53            | 1,109,642.57           |
| 210204      | Ажилгүйдлийн даатгал  | 810,430.53            | 1,110,055.40           |
| 210205      | Эрүүл мэндийн даатгал   | 3,431,043.12          | 4,440,884.01           |
| <b>2103</b> | <b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>                                      | <b>83,629,859.00</b>  | <b>149,078,747.90</b>  |
| 210301      | Гэрэл, цахилгаан  | 1,144,579.00          | 2,769,736.00           |
| 210302      | Түлш, халаалт   | 76,125,280.00         | 140,189,011.90         |
| 210303      | Цэвэр, бохир ус   | 6,360,000.00          | 6,120,000.00           |
| <b>2104</b> | <b>Хангамж, бараа материалын зардал</b>   | <b>2,872,380.61</b>   | <b>2,460,200.00</b>    |
| 210401      | Бичиг хэрэг   | 691,000.00            | 486,000.00             |
| 210402      | Тээвэр, шатахуун  | 915,936.00            | 739,200.00             |
| 210403      | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр  | 114,344.61            | 893,000.00             |
| 210405      | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал                             | 420,000.00            | -                      |
| 210406      | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс   | 731,100.00            | 342,000.00             |
| <b>2105</b> | <b>Нормативт зардал</b>   | <b>500,000.00</b>     | <b>200,000.00</b>      |
| 210503      | Нормын хувцас, зөөлөн эдлэл   | 500,000.00            | 200,000.00             |
| <b>2106</b> | <b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>  | <b>58,604,000.00</b>  | <b>1,745,800.00</b>    |
| 210601      | Багаж, техник, хэрэгсэл   | -                     | 745,800.00             |
| 210604      | Урсгал засвар   | 58,604,000.00         | 1,000,000.00           |
| <b>2107</b> | <b>Томилолт, зочны зардал</b>   | <b>1,806,000.00</b>   | <b>670,000.00</b>      |
| 210702      | Дотоод албан томилолт   | 1,806,000.00          | 670,000.00             |
| <b>2108</b> | <b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>                       | <b>7,060,684.00</b>   | <b>2,500,000.00</b>    |
| 210801      | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж                  | 5,765,000.00          | 2,500,000.00           |
| 210806      | Мэдээлэл, технологийн үйлчилгээ   | 1,155,000.00          | -                      |
| 210807      | Газрын төлбөр   | 140,684.00            | -                      |
| <b>2109</b> | <b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>  | <b>106,386,597.57</b> | <b>79,192,305.66</b>   |
| 210901      | Бараа үйлчилгээний бусад зардал   | -                     | 2,107,700.00           |
| 210903      | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол  | 106,386,597.57        | 77,084,605.66          |
| <b>213</b>  | <b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>   | <b>103,374,627.71</b> | <b>57,871,645.98</b>   |
| <b>2132</b> | <b>Бусад урсгал шилжүүлэг</b>   | <b>20,981,273.00</b>  | <b>10,760,800.00</b>   |
| 213204      | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал  | 723,000.00            | 941,200.00             |
| 213207      | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж                                   | 5,079,173.00          | -                      |
| 213208      | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 7,290,000.00          | 9,819,600.00           |
| 213209      | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал   | 7,889,100.00          |                        |
| <b>2133</b> | <b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>                                    | <b>42,770,613.71</b>  | <b>47,110,845.98</b>   |
| 213303      | Төвлөрүүлэх шилжүүлэг   | 42,770,613.71         | 47,110,845.98          |
| <b>2134</b> | <b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>           | <b>39,622,741.00</b>  | <b>-</b>               |
| 213403      | Төвлөрүүлэх шилжүүлэг   | 39,622,741.00         | -                      |
| <b>II</b>   | <b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>  | <b>513,070,400.23</b> | <b>534,174,767.67</b>  |
| <b>III</b>  | <b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>   | <b>7,134,701.38</b>   | <b>(15,778,251.67)</b> |
| <b>225</b>  | <b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>  | <b>650,450.14</b>     | <b>80,000.18</b>       |
| 225001      | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз  | 650,450.14            | 80,000.18              |
| <b>IV</b>   | <b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>                                       | <b>(650,450.14)</b>   | <b>(80,000.18)</b>     |
| <b>V</b>    | <b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>  | <b>6,484,251.24</b>   | <b>(15,858,251.85)</b> |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/Төгрөгөөр/

| Данс        | Үзүүлэлт   | Өмнөх он              | Тайлант он            |
|-------------|--|-----------------------|-----------------------|
| <b>I</b>    | <b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>                        | <b>430,490,101.61</b> | <b>458,776,516.00</b> |
| <b>12</b>   | <b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>   | <b>41,544,525.46</b>  | <b>55,948,916.00</b>  |
| <b>120</b>  | <b>Нийтлэг татварын бус орлого</b>                                   | <b>41,544,525.46</b>  | <b>55,948,916.00</b>  |
| 120004      | Төсөв байгууллагын өөрийн орлого                                     | 41,544,525.46         | 55,948,916.00         |
| 1200042     | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих                            | 41,544,525.46         | 55,948,916.00         |
| <b>13</b>   | <b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>                                 | <b>388,945,576.15</b> | <b>402,827,600.00</b> |
| <b>1310</b> | <b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>                                       | <b>222,265,976.15</b> | <b>213,133,600.00</b> |
| 131001      | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт                                    | 222,265,976.15        | 213,133,600.00        |
| <b>1320</b> | <b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>                                | <b>166,679,600.00</b> | <b>189,694,000.00</b> |
| 132001      | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/  | 166,679,600.00        | 189,694,000.00        |
| <b>II</b>   | <b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>                         | <b>435,693,802.66</b> | <b>458,776,516.00</b> |
| <b>21</b>   | <b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>   | <b>435,693,802.66</b> | <b>458,776,516.00</b> |
| <b>210</b>  | <b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>                               | <b>332,319,174.95</b> | <b>400,904,870.02</b> |
| <b>2101</b> | <b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>                             | <b>170,008,646.37</b> | <b>211,028,998.97</b> |
| 210101      | Үндсэн цалин   | 109,414,177.25        | 130,508,961.94        |
| 210102      | Нэмэгдэл   | 50,461,289.12         | 71,796,748.68         |
| 210104      | Урамшуулал   | 10,133,180.00         | 8,723,288.35          |
| <b>2102</b> | <b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>                | <b>22,254,604.97</b>  | <b>28,332,923.15</b>  |
| 210201      | Тэтгэврийн даатгал   | 15,220,643.91         | 19,452,228.19         |
| 210202      | Тэтгэмжийн даатгал   | 1,708,435.02          | 2,220,112.80          |
| 210203      | ҮОМШӨ-ний даатгал  | 874,164.50            | 1,109,642.15          |
| 210204      | Ажилгүйдлийн даатгал   | 864,119.50            | 1,110,055.40          |
| 210205      | Эрүүл мэндийн даатгал  | 3,587,242.04          | 4,440,884.61          |
| <b>2103</b> | <b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>                     | <b>83,629,859.00</b>  | <b>149,078,747.90</b> |
| 210301      | Гэрэл, цахилгаан   | 1,144,579.00          | 2,769,736.00          |
| 210302      | Түлш, халаалт  | 76,125,280.00         | 140,189,011.90        |
| 210303      | Цэвэр, бохир ус  | 6,360,000.00          | 6,120,000.00          |
| <b>2104</b> | <b>Хангамж, бараа материалын зардал</b>                              | <b>2,572,380.61</b>   | <b>2,580,200.00</b>   |
| 210401      | Бичиг хэрэг  | 596,000.00            | 486,000.00            |
| 210402      | Тээвэр, шатахуун   | 915,936.00            | 739,200.00            |
| 210403      | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр                                   | 114,344.61            | 893,000.00            |
| 210404      | Ном, хэвлэл  | 35,000.00             | 120,000.00            |
| 210405      | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал            | 420,000.00            | -                     |
| 210406      | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс                          | 491,100.00            | 342,000.00            |
| <b>2105</b> | <b>Нормативт зардал</b>  | <b>500,000.00</b>     | <b>200,000.00</b>     |
| 210503      | Нормын хувцас, зөөлөн эдлэл  | 500,000.00            | 200,000.00            |
| <b>2106</b> | <b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>                             | <b>43,427,000.00</b>  | <b>4,406,300.00</b>   |
| 210601      | Багаж, техник, хэрэгсэл  |                       | 3,406,300.00          |
| 210604      | Урсгал засвар  | 43,427,000.00         | 1,000,000.00          |
| <b>2107</b> | <b>Томиллолт, зочны зардал</b>                                       | <b>1,806,000.00</b>   | <b>670,000.00</b>     |
| 210702      | Дотоод албан томиллолт   | 1,806,000.00          | 670,000.00            |
| <b>2108</b> | <b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>      | <b>7,120,684.00</b>   | <b>2,500,000.00</b>   |
| 210801      | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 5,825,000.00          | 2,500,000.00          |
| 210806      | Мэдээлэл, технологийн үйлчилгээ                                      | 1,155,000.00          | -                     |
| 210807      | Газрын төлбөр  | 140,684.00            | -                     |
| <b>2109</b> | <b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>                               | <b>1,000,000.00</b>   | <b>2,107,700.00</b>   |
| 210901      | Бараа үйлчилгээний бусад зардал                                      | 1,000,000.00          | 2,107,700.00          |
| <b>213</b>  | <b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>  | <b>103,374,627.71</b> | <b>57,871,645.98</b>  |
| <b>2132</b> | <b>Бусад урсгал шилжүүлэг</b>  | <b>20,981,273.00</b>  | <b>10,760,800.00</b>  |
| 213204      | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал                       | 723,000.00            | 941,200.00            |
| 213207      | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж                  | 5,079,173.00          | -                     |

|             |   |                        |                      |
|-------------|---|------------------------|----------------------|
| 213208      | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 7,290,000.00           | 9,819,600.00         |
| 213209      | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал   | 7,889,100.00           | -                    |
| <b>2133</b> | <b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>                                    | <b>42,770,613.71</b>   | <b>47,110,845.98</b> |
| 213303      | Төвлөрүүлэх шилжүүлэг   | 42,770,613.71          | 47,110,845.98        |
| <b>2134</b> | <b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>           | <b>39,622,741.00</b>   | <b>-</b>             |
| 213403      | Төвлөрүүлэх шилжүүлэг   | 39,622,741.00          | -                    |
| <b>III</b>  | <b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>                               | <b>(5,203,701.05)</b>  | <b>-</b>             |
| <b>V</b>    | <b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>                                      | <b>6,929,300.00</b>    | <b>-</b>             |
|             | Дотоод эх үүсвэрээр   | 6,929,300.00           | -                    |
| 223001      | Бусад хөрөнгө   | 6,929,300.00           | -                    |
| <b>VI</b>   | <b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>            | <b>(6,929,300.00)</b>  | <b>-</b>             |
| <b>VIII</b> | <b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>                                      | <b>(12,133,001.05)</b> | <b>-</b>             |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/Төгрөгөөр/

| Д/Д | Үзүүлэлт                              | Засгийн газрын хувь оролцоо | Дахин үнэлгээний нэмэгдэл | Хуримтлагдсан үр дүн | Нийт дүн        |
|-----|---------------------------------------|-----------------------------|---------------------------|----------------------|-----------------|
| 1   | 2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 489,627,050.91              | 135,168,319.89            | 331,871,441.72       | 956,666,812.52  |
| 2   | Тайлант үеийн үр дүн                  | -                           | -                         | (15,858,251.85)      | (15,858,251.85) |
| 3   | 2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 489,627,050.91              | 135,168,319.89            | 316,013,189.87       | 940,808,560.67  |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/Төгрөгөөр/

| Данс        | Үзүүлэлт  | Төлөвлөгөө            | Гүйцэтгэл             | Зөрүү дүн            |
|-------------|---|-----------------------|-----------------------|----------------------|
| <b>1</b>    | <b>ТАТААС, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>                   | <b>434,699,300.00</b> | <b>355,716,754.02</b> | <b>78,982,545.98</b> |
| <b>131</b>  | <b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>                        | <b>220,315,700.00</b> | <b>166,022,754.02</b> | <b>54,292,945.98</b> |
| 131001      | Улсын төсвөөс санхүүжих                               | 220,315,700.00        | 166,022,754.02        | 54,292,945.98        |
| <b>132</b>  | <b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>                 | <b>214,383,600.00</b> | <b>189,694,000.00</b> | <b>24,689,600.00</b> |
| 132001      | Орон нутгийн төсвөөс                                  | 214,383,600.00        | 189,694,000.00        | 24,689,600.00        |
| 120004      | ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС                 | 65,437,900.00         | 55,948,916.00         | 9,488,984.00         |
| 1200042     | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих             | 65,437,900.00         | 55,948,916.00         | 9,488,984.00         |
| <b>1</b>    | <b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>                | <b>500,137,200.00</b> | <b>411,665,670.02</b> | <b>88,471,529.98</b> |
| <b>21</b>   | <b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>                                  | <b>500,137,200.00</b> | <b>411,665,670.02</b> | <b>88,471,529.98</b> |
| <b>210</b>  | <b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>                | <b>489,376,400.00</b> | <b>400,904,870.02</b> | <b>88,471,529.98</b> |
| <b>2101</b> | <b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>              | <b>226,024,100.00</b> | <b>211,028,998.97</b> | <b>14,995,101.03</b> |
| 210101      | Үндсэн цалин  | 137,499,800.00        | 130,508,961.94        | 6,990,838.06         |
| 210102      | Нэмэгдэл  | 74,193,500.00         | 71,796,748.68         | 2,396,751.32         |
| 210104      | Урамшуулал  | 14,330,800.00         | 8,723,288.35          | 5,607,511.65         |
| <b>2102</b> | <b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b> | <b>28,253,100.00</b>  | <b>28,332,923.15</b>  | <b>(79,823.15)</b>   |
| 210201      | Тэтгэврийн даатгал                                    | 19,419,400.00         | 19,452,228.19         | (32,828.19)          |
| 210202      | Тэтгэмжийн даатгал                                    | 2,208,500.00          | 2,220,112.80          | (11,612.80)          |
| 210203      | ҮОМШӨ-ний даатгал                                     | 1,104,200.00          | 1,109,642.15          | (5,442.15)           |
| 210204      | Ажилгүйдлийн даатгал                                  | 1,104,200.00          | 1,110,055.40          | (5,855.40)           |
| 210205      | Эрүүл мэндийн даатгал                                 | 4,416,800.00          | 4,440,884.61          | (24,084.61)          |
| <b>2103</b> | <b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>      | <b>219,315,700.00</b> | <b>149,078,747.90</b> | <b>70,236,952.10</b> |

|             |   |                       |                       |                      |
|-------------|---|-----------------------|-----------------------|----------------------|
| 210301      | Гэрэл, цахилгаан  | 4,843,700.00          | 2,769,736.00          | 2,073,964.00         |
| 210302      | Түлш, халаалт   | 207,434,900.00        | 140,189,011.90        | 67,245,888.10        |
| 210303      | Цэвэр, бохир ус   | 7,037,100.00          | 6,120,000.00          | 917,100.00           |
| <b>2104</b> | <b>Хангамж, бараа материалын зардал</b>   | <b>2,750,200.00</b>   | <b>2,580,200.00</b>   | <b>170,000.00</b>    |
| 210401      | Бичиг хэрэг   | 560,000.00            | 486,000.00            | 74,000.00            |
| 210402      | Тээвэр, шатахуун  | 820,000.00            | 739,200.00            | 80,800.00            |
| 210403      | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр  | 900,000.00            | 893,000.00            | 7,000.00             |
| 210404      | Ном, хэвлэл   | 120,000.00            | 120,000.00            | -                    |
| 210406      | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс   | 350,200.00            | 342,000.00            | 8,200.00             |
| <b>2105</b> | <b>Нормативт зардал</b>   | <b>200,000.00</b>     | <b>200,000.00</b>     | <b>-</b>             |
| 210503      | Нормын хувцас, зөөлөн эдлэл   | 200,000.00            | 200,000.00            | -                    |
| <b>2106</b> | <b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>  | <b>4,418,900.00</b>   | <b>4,406,300.00</b>   | <b>12,600.00</b>     |
| 210601      | Багаж, техник, хэрэгсэл   | 3,418,900.00          | 3,406,300.00          | 12,600.00            |
| 210604      | Урсгал засвар   | 1,000,000.00          | 1,000,000.00          | -                    |
| <b>2107</b> | <b>Томилолт, зочны зардал</b>   | <b>1,150,000.00</b>   | <b>670,000.00</b>     | <b>480,000.00</b>    |
| 210702      | Дотоод албан томилолт   | 1,150,000.00          | 670,000.00            | 480,000.00           |
| <b>2108</b> | <b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>                       | <b>3,900,000.00</b>   | <b>2,500,000.00</b>   | <b>1,400,000.00</b>  |
| 210801      | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж                  | 3,750,000.00          | 2,500,000.00          | 1,250,000.00         |
| 210802      | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох  | 150,000.00            |                       | 150,000.00           |
| <b>2109</b> | <b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>  | <b>3,364,400.00</b>   | <b>2,107,700.00</b>   | <b>1,256,700.00</b>  |
| 210901      | Бараа үйлчилгээний бусад зардал   | 3,364,400.00          | 2,107,700.00          | 1,256,700.00         |
| <b>213</b>  | <b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>   | <b>10,760,800.00</b>  | <b>10,760,800.00</b>  | <b>-</b>             |
| <b>2132</b> | <b>Бусад урсгал шилжүүлэг</b>   | <b>10,760,800.00</b>  | <b>10,760,800.00</b>  | <b>-</b>             |
| 213204      | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал  | 941,200.00            | 941,200.00            | -                    |
| 213208      | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 9,819,600.00          | 9,819,600.00          | -                    |
| <b>2</b>    | <b>НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН</b>  | <b>500,137,200.00</b> | <b>411,665,670.02</b> | <b>88,471,529.98</b> |
| <b>31</b>   | <b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>                               | <b>-</b>              | <b>-</b>              | <b>-</b>             |
| <b>31</b>   | <b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>                              | <b>-</b>              | <b>-</b>              | <b>-</b>             |

### 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 58,441.2 мянган төгрөгийн алдаа<sup>1</sup> илэрснээс аудитын явцад 58,441.2 мянган төгрөгийн алдааг залруулсан.

Залруулсан алдаа:

- Мөнгөн гүйлгээний тайлан дахь биет ба биет бус хөрөнгө худалдан авах зардалд 2,670.0 мянган төгрөгийг тусгаагүй байна.
- Цалингийн өглөг дансыг цалингийн тооцоололтой тулган баталгаажуулахад 26,677.1 мянган төгрөгөөр илүү тайлагнасан байна.
- Бараа материалын түүвэр тооллого хөрөнгийн шинжтэй 19,000.0 мянган төгрөгийн тайзны хөшиг тогтоох граниз карказ, 9,000.0 төгрөгийн гэрлийн суурь карказ тогтоогч граниз тюль бараа материалаар бүртгэсэн,
- Өглөгийн тайланд нийгмийн даатгалын өглөг 1,094.1 мянган төгрөгийг тусгаагүй байна.

Аудитаар нийт 33,530.4 мянган төгрөгийн зөрчил<sup>2</sup> илэрснээс, 3,594.1 мянган төгрөгийн 2 албан шаардлага хүргүүлж, 29,936.3 мянган төгрөгийн 2 зөвлөмжийг өглөө.

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 33,530.4 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа болон зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 23,963.9 мянган төгрөгөөр их тул “Хязгаарлалттай” дүгнэлт өглөө.

### **3.1 Төлбөрийн акт**

Аудитаар төлбөрийн акт тогтоогдоогүй.

### **3.2 Албан шаардлага**

1. Нийгмийн даатгалын шимтгэл 1,094.1 мянган төгрөгийн өглөгтэй ажилласан байна.

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" заалтыг хэрэгжүүлээгүй, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна

Шийдвэрлэсэн нь: Хууль журам хэрэгжүүлэн өглөгийг барагдуулж, төсвийг зохистой удирдаж ажиллах албан шаардлага өгөх.

2. Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардлаас 2,500.0 мянган төгрөгийн өргөмжлөл, хүүхдийн бэлэг, дугуйн уралдаанд зарцуулсан байна.

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5 "Төсвийн шууд захирагч нь төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ", 16.5.5 "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20 дугаар зүйлийн 20.2.4 "нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах" заалтыг тус тус хэрэгжүүлээгүй, санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийг зориулалтын дагуу зарцуулж ажиллах албан шаардлага хүргүүлэх.

### **3.3 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Хөрөнгөтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Хуримтлагдсан элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 17 нэр төрлийн үндсэн хөрөнгүүдийн үнэ болон ашиглах хугацааг шинэчлэн тогтоолгоогүй бүртгэсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль 20 дугаар зүйл 20.2 "Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67 "Өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтад бүртгэлээр тавих хяналт шалгалтыг тухайн хуулийн этгээдийн ерөнхий нягтлан бодогч хариуцна", Сангийн сайдын 2014 оны 249 тоот тушаал "Хөрөнгөнд холбогдох эдийн засгийн ирээдүйн өгөөж буюу үйлчилгээний чадавхыг тухайн байгууллага хүртэх магадлалтай ба хөрөнгийн өртөг эсвэл бодит үнэ цэнийг найдвартай хэмжих боломжтой тохиолдолд үндсэн хөрөнгөөр хүлээн зөвшөөрч бүртгэнэ" заалтыг тус тус хэрэгжүүлээгүй, санхүүгийн тайлангийн үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Үндсэн хөрөнгүүдийн үнэ болон ашиглах хугацааг эрх бүхий байгууллагын шийдвэрээр шинэчлэн тогтоох.

2. Цалин хөлстэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Нийгмийн даатгалын шимтгэл 15,977.1 мянган төгрөг, хувь хүний орлогын албан татвар 12,079.2 мянган төгрөг, нийт 28,056.3 мянган төгрөгийг цалингийн өглөг дансанд тусгаагүй шууд зардалд тайлагнасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 "үнэн зөв байх", 6 дугаар зүйлийн 6.1 "аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккруэл сууриар хөтөлнө", 20 дугаар зүйлийн 20.2.5 "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1 "төсвийн байгууллага нь

нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу бүрэн аккруэл суурьтай нягтлан бодох бүртгэл хөтөлнө", Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар дугаар тушаалаар баталсан " Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ын гуравдугаар бүлгийн 3.5 дахь заалтыг тус тус хэрэгжүүлээгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Өгсөн зөвлөмж: Хууль журмын дагуу цалингийн тооцооллыг хийж, аккруэль суурийн дагуу цалингийн өглөг, холбогдох татварын өглөг дансаар дамжуулж бүртгэх.

### 3. Зардалтай холбоотой асуудал

Илрүүлэлт: Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлаас 1,880.0 мянган төгрөгийн өргөмжлөл, бараа худалдан авч бараа материалын тайланд тусгаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 13 дугаар зүйлийн 13.4 "аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна", 18 дугаар зүйлийн 18.1 "нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20 дугаар зүйлийн 20.2.4 "нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах" заалтыг тус тус хэрэгжүүлээгүй, санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Зардлын ангилал зөрчиж худалдан авалт хийхгүй байх, бараа материалыг тухай бүрд нь бараа материалын тайланд бүртгэх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2026 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

##### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

| Д.д | Алдааны товч утга   | Нийт алдаа |                 | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан |     | Буруу тусган илэрхийлсэн |     | Үүнээс     |                 |              |     | Зөвлөмж |     |
|-----|---|------------|-----------------|-----------------------------------|-----|--------------------------|-----|------------|-----------------|--------------|-----|---------|-----|
|     |   |            |                 |                                   |     |                          |     | Залруулсан |                 | Залруулаагүй |     |         |     |
|     |   | Тоо        | Дүн             | Тоо                               | Дүн | Тоо                      | Дүн | Тоо        | Дүн             | Тоо          | Дүн | Тоо     | Дүн |
| 1   | Мөнгөн гүйлгээний тайлан дахь биет ба биет бус хөрөнгө худалдан авах зардалд 2,670.0 мянган төгрөгийг тусгаагүй байна.  | 1          | 2,670.0         | -                                 | -   | -                        | -   | 1          | 2,670.0         | -            | -   | -       | -   |
| 2   | Цалингийн өглөг дансыг цалингийн тооцоололтой тулган баталгаажуулахад 26,677.1 мянган төгрөгөөр илүү тайлагнасан.   | 1          | 26,677.1        | -                                 | -   | -                        | -   | 1          | 26,677.1        | -            | -   | -       | -   |
| 3   | Бараа материалын түүвэр тооллого хөрөнгийн шинжтэй 19,000.0 мянган төгрөгийн тайзны хөшиг тогтоох граниз карказ, 9,000.0 төгрөгийн гэрлийн суурь карказ тогтоогч граниз тюль бараа материалаар бүртгэсэн. | 1          | 28,000.0        | -                                 | -   | -                        | -   | 1          | 28,000.0        | -            | -   | -       | -   |
| 4   | Өглөгийн тайланд нийгмийн даатгалын өглөг 1,094.1 төгрөгийг тусгаагүй.  | 1          | 1,094.1         | -                                 | -   | -                        | -   | 1          | 1,094.1         | -            | -   | -       | -   |
|     | <b>Дүн</b>  | <b>4</b>   | <b>58,441.2</b> | -                                 | -   | -                        | -   | <b>4</b>   | <b>58,441.2</b> | -            | -   | -       | -   |

##### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

| Д.д | Зөрчлийн товч утга   | Нийт зөрчил |         | Үүнээс        |     |                 |         |         |     |                                      |                     |   |     |
|-----|--|-------------|---------|---------------|-----|-----------------|---------|---------|-----|--------------------------------------|---------------------|---|-----|
|     |  |             |         | Төлбөрийн акт |     | Албан шаардлага |         | Зөвлөмж |     | Хариуцлага тооцуулах албан шаардлага |                     | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал |     |
|     |  | Тоо         | Дүн     | Тоо           | Дүн | Тоо             | Дүн     | Тоо     | Дүн | Тоо                                  | Албан тушаалтны тоо | Тоо   | Дүн |
| 1   | Нийгмийн даатгалын шимтгэл 1,094.1 мянган төгрөгийн өглөгтэй ажилласан.  | 1           | 1,094.1 | -             | -   | 1               | 1,094.1 | -       | -   | -                                    | -                   | -   | -   |
| 2   | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардлаас 2,500.0 мянган төгрөгийн өргөмжлөл, хүүхдийн бэлэг, дугуйн уралдаанд зарцуулсан. | 1           | 2,500.0 | -             | -   | 1               | 2,500.0 | -       | -   | -                                    | -                   | -   | -   |
| 3   | Хуримтлагдсан элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 17 нэр төрлийн үндсэн хөрөнгүүдийн үнэ болон ашиглах хугацааг шинэчлэн тогтоолгоогүй бүртгэсэн.                      | 1           | -       | -             | -   | -               | -       | 1       | -   | -                                    | -                   | -   | -   |

|   |   |          |                 |   |   |          |                |          |                 |   |   |   |   |
|---|---|----------|-----------------|---|---|----------|----------------|----------|-----------------|---|---|---|---|
| 4 | Нийгмийн даатгалын шимтгэл 15,977.1 мянга , ХАОАТ 12,079.2 мянга нийт 28,056,3 төгрөгийг цалингийн өглөг дансанд тусгаагүй шууд зардалд тайлагнасан.                        | 1        | 28,056.3        | - | - | -        | -              | 1        | 28,056.3        | - | - | - | - |
| 5 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлаас 1,880.0 мянган төгрөгийн өргөмжлөл, бараа худалдан авч бараа материалын тайланд тусгаагүй. | 1        | 1,880.0         | - | - | -        | -              | 1        | 1,880.0         | - | - | - | - |
|   | <b>Дүн</b>  | <b>5</b> | <b>33,530.4</b> | - | - | <b>2</b> | <b>3,594.1</b> | <b>3</b> | <b>29,936.3</b> | - | - | - | - |